



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жамъян Д. Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.05.20 № ХЭГ/1735
танай _____ -ны № _____ -Т

Хариу хүргүүлэх тухай

Танаас Жеффри Эпштэйнтэй холбоотой олон улсын хэргийн материал нээлттэй болсонтой холбогдуулан тухайн материал дахь Монгол Улстай холбоотой мэдээллүүдийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулттай танилцлаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу Жеффри Эпштэйнтэй холбоотой олон улсын хэргийн материал дахь Монгол Улстай холбоотой мэдээллүүдийг нарийвчлан нягтлан шалгах, үнэлэлт дүгнэлт өгөх, гэмт хэргийн шинжийг агуулж байгаа эсэхийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шалгах үүрэг бүхий Ажлын хэсэг Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газрын дарга нарын хамтарсан тушаалаар байгуулагдан ажиллаж байна.

Иймд асуултад дурдсан дэлгэрэнгүй мэдээллийг одоогийн байдлаар хүргүүлэх боломжгүй байгааг Танд үүгээр мэдэгдье.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 1/2604 дугаартай албан бичгийг хавсаргав.

Хавсралт 2 хуудастай.



Монгол Улсын Засгийн газар
Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Баттөмөр Энхбаяр
2026.05.21 10:29



МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26-75-33
Цахим шуудан: info@mojha.gov.mn
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.05.18 № 1/2604
танай 2026.05.11 -ны № ХЭГ/1557 -т

Хариу хүргүүлэх тухай

Засгийн газрын Хэрэг газрын 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн ХЭГ/1557 дугаартай албан бичгийн хавсралтаар Улсын Их Хурлын Гишүүн Л.Оюун-Эрдэнээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж гаргасан “Жеффри Эпштэйнтэй холбоотой материал болон Монгол Улсын эрх ашигт холбогдох асуудлыг тодруулах тухай” асуултад холбогдох мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

1. Америкийн Нэгдсэн Улсын Хууль зүйн яамнаас ил тод, нээлттэй болгож www.justice.gov/epstein цахим хаягт байршуулсан “Ж.Эпштэйний хавтаст хэрэг” гэх хэрэгт Ж.Эпштэйнтэй холбоотой 12 багц 3,500,000 гаруй хуудас баримт, 180,000 гэрэл зураг, 2,000 орчим видео бичлэгт Монгол Улстай холбогдох нийт 1483 орчим мэдээлэл илэрсэн.

Хайлтын үр дүнд Монгол Улстай холбоотой “Mongolia” гэх утгаар 905, Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж “Elbegdorj” гэх утгаар 53, Ерөнхийлөгч асан Х.Баттулга “Battulga” гэх утгаар 81, Ерөнхий сайд асан Ч.Сайханбилэг “Saikhanbileg” гэх утгаар 4, Гадаад харилцааны сайд асан Л.Пүрэвсүрэн “Purevsuren” гэх утгаар 222, “Либерти Партнерс” компанийн захирал Ч.Ганбат “Ganbat” гэх утгаар 196, “Oyutolgoi” гэх утгаар 14, “Mongolian girl” гэх утгаар 2, “Erdenet” гэх утгаар 2, “Tavantolgoi” гэх утгаар 2, “Golomt bank” гэх утгаар 2 мэдээлэл тус тус бүртгэгдсэн.

Ж.Эпштэйнтэй Гадаад хэргийн сайд асан Л.Пүрэвсүрэн нь 2013 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хооронд, Ч.Ганбат нь 2013 оны 09 дүгээр сарын 23-ны өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хооронд тус тус харилцсан. Тэдгээрийн харилцсан мэдээлэлд Монгол Улсын Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж, Х.Баттулга, Монгол Улсын Ерөнхий сайд асан Ч.Сайханбилэг нарын нэр дурдагдсан байна.

Дээрх нэр дурдагдсан хүмүүсийг Ж.Эпштэйний бэлгийн мөлжлөг, хүний наймааны гэмт хэрэгт шууд холбоотой гэх баримт, мэдээлэл илрээгүй. Америкийн Нэгдсэн Улсын Хууль зүйн яамны цахим хаягт байршуулсан мэдээлэлд улс төр, хөрөнгө оруулалт, геополитик, аюулгүй байдал, уул уурхай болон олон улсын харилцааны хүрээний мэдээллүүд байна;


2. Америкийн Нэгдсэн Улс дахь “Ж.Эпштэйний” гэх хэрэгт Монгол Улсын хохирсон болон холбогдсон иргэн байгаа эсэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл,

материалуудыг гаргуулан авах асуудлаар Америкийн Нэгдсэн Улсын Интерполын Үндэсний төв товчоонд Интерполын шугамаар хандахад тус товчооноос Америкийн Нэгдсэн Улсын Хууль зүйн яаманд эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг ирүүлэх шаардлагатай гэсэн хариу ирүүлсэн.

Монгол Улс болон Америкийн Нэгдсэн Улс хооронд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ байгуулаагүй бөгөөд Прокурорын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д "Прокурорын байгууллага нь олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг хариуцан зохион байгуулах төв байгууллага байна" гэж, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д "хүсэлтийг хүлээн авах, эрх бүхий байгууллагад уламжлах, түүнийг гүйцэтгүүлэхээр холбогдох байгууллагад шилжүүлэх" гэж тус тус заасан байна;

3. Асуултад нэр дурдсан Израйл Улсын иргэн Barak Ehud (1942.02.12-ны өдөр төрсөн, ПД: 00300554) нь Буянт-Ухаа агаарын замын боомтоор 2013 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр улсын хилээр орох, мөн оны 05 дугаар сарын 03-ны өдөр гарах чиглэлд бүртгэгдсэн байна. Мөн асуултад нэр дурдагдсан 3 иргэний мэдээлэл бүрэн өгөгдөөгүй тул улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн мэдээллийн сангаас шүүх боломжгүй байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд харилцан санал солилцсоны үндсэн дээр "Ж.Эпштэйний" гэх асуудлын Монгол Улстай холбоотой мэдээллүүдийг нарийвчлан нягтлах, үнэлэлт дүгнэлт өгөх, гэмт хэргийн шинжийг агуулж байгаа эсэхийг шалгах үүрэг бүхий ажлын хэсгийг Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газрын дарга нарын хамтарсан тушаалаар байгуулан, холбогдох ажиллагааг явуулж байна.

 Хууль зүй, дотоод хэргийн яам
Удирдлага
Сайд
Сайнбуян Амарсайхан
2026.05.19 12:33